**БАТЛАВ:** БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА Ж.ДАШ-ЯЙЧИЛ

# СУМДЫН ТӨВИЙН УНДНЫ УСНЫ ХУДАГТ УС ЗӨӨЛРҮҮЛЭХ ТӨХӨӨРӨМЖ СУУРИЛУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024.02.05 Зуунмод сум

| № | Ажлын өгөгдөл | Ажлын даалгавар |
|---|---|---|
| 1. | Хийгдэх ажлын нэр | Сумдын /4/ төвийн ундны усны худаг, усан санд ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах |
| 2. | Стандарт | Төхөөрөмжөөс гарсан ус нь "*Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018*" стандартыг хангана. |
| 3. | Худгийн байршил | - Жаргалант (Талбулаг)<br>- Батсүмбэр (Баянгол)<br>- Мөнгөнморьт (Хөгшчүүл)<br>- Сэргэлэн (4-зөрлөг) |
| 4. | Төсөв | Нийт 62 сая төгрөг |
| 5. | Гүйцэтгэх ажил, захиалагчийн санал | - **Ус зөөлрүүлэх олон шатлалт WS3000 төхөөрөмж** Усны хатуулаг чанараас хамаарч цахилгаан соронзон өндөр давтамжит ус зөөлрүүлэгч,кварцит элсэн шүүлтүүр,идэвхижүүлсэн нүүрсэн шүүлтүүр, катионтот ион зохицуулагч шүүлтүүрээс тохиромжтойг суурилуулна./хатуулаг бууруулж, бохирдлыг шүүх, химийн бодис хэрэглэхгүй ашиглахад хялбар, шүүлтүүрийг цэвэрлэхэд түвэггүй, автомат өөрийгөө угаах горимтой байх, цахилгаан зарцуулалт бага, унд ахуйн хэрэгцээнээс бусад хэрэглээнд ус өгөх боломж бүрдсэн байх /<br>- **Ус нөөцлөх сав** /худгийн хэмжээнд тохирсон, 1-1.5 тн багтаамжтай, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ус хадгалах зориулалтын материал хийцтэй, мэдрэгч, хөвүүртэй байх/<br>- **Халаагуур** /уг төхөөрөмж нь -50$^0$с +40$^0$с градуст тасралтгүй ажиллах боломжтой байх үүднээс нэмэлт халаагуур, ус дамжих шугам хоолойн дулаалга шийдэж өгөх/<br>- **Холбох, туслах хэрэгсэл** /сангийн материал PPR, гадна, дотор цахилгаан болон сүлжээний монтаж |

| | | |
|---|---|---|
| | | холболтыг аюулгүй байдлыг хангасан тоноглол, далдлагч хийх/<br>- **Аюулгүй ажиллагааны самбар** /төхөөрөмжийн ажиллах горим схем, гүйцэтгэгчийн нэр хаяг, утас зэрэг мэдээллийг агуулсан зөвлөмжийг худагт байрлуулна/ |
| 6. | Хүчин чадал | - 1-1.5$м^3$/цаг |
| 7. | Баталгаат хугацаа | **2 жил** |
| 8. | Мэргэжлийн шаардлага, зөвшөөрөл | - **Зөөлрүүлэх төхөөрөмжийн сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглах**<br>- Хэрэглэгчдэд ашиглахад хялбар, төвөггүй байх<br>- **Усны мэргэжлийн байгууллага буюу ус хангамж шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж угсралт, усны барилга байгууламж барих, сэргээн засварлах, шинэчлэх эрхтэй аж ахуйн нэгж байна.** |
| 9. | Ашиглалтад хүлээлгэн өгөх | Ажлын гүйцэтгэлийг захиалагч талаас томилогдсон ажлын хэсэг газар дээр нь очиж шалган, үнэлэлт дүгнэлт өгч хүлээн авна.<br>Худгийн усыг зөөлрүүлэх төхөөрөмж тавихаас өмнө болон дараа нь итгэмжлэгдсэн лаборториор шинжлүүлж ундны усны стандарт MNS0900;2018-д нийцсэн, хатуулаг чанар нь буурсан тохиолдолд хүлээлгэн өгнө. |

Боловсруулсан:

Мэргэжилтэн Ж.Оюун-Эрдэнэ